

Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ **Error! Reference source not found.**-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

Барааны нэр: Хуурай хүнсний бүтээгдэхүүн

| № | Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.) | Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.) | Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана) |
|---|---|--|---|
| 1 | <p>Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Нийлүүлэгч тал нь өөрсдийн зардлаар тээвэрлэлтийн горимыг баримтлан дагалдах бичиг баримтын хамт хүргэж ирнэ. Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд нийцсэн байна. Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна. Лабораторийн шинжилгээний бичигтэй зориулалтын савлагатай байна.</p> <p>Гурил болон гоймонгийн төрөл: MNS:0244-2009 чанарын шаардлага хангасан үйлдвэрийн аргаар боловсруулсан эх орны болон импортын, олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна. Урсамтгай биш шинж чанартай, чийг алдаагүй, хөгцөрч муудаагүй, үүрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй байна. 5-аас доошгүй төрөл байна. /шпагети, дун, хөндий, луувантай, сонгинотой г.м/</p> <p>Будааны төрөл: MNS ISO7301:2000</p> <p>/Цагаан, хөх тарианы будаа/ Өнгө: Төрөл бүрийн толбо бүхий тод шар, цагаан, бор өнгөтэй байна. Амт, үнэр: Будаа нь өвөрмөц үнэртэй, исгэлэн, гашуун, хөгц зэрэг бусад гадны үнэр амтгүй байна. Зажлалт:</p> | | |

| | | |
|--|--|--|
| <p>Шүдэнд мэдэгдэх элсэрхэг хатуу зүйлгүй байна.</p> <p>Элсэн чихэр: MNS CAC 212:2014 стандартыг хангасан байна. Чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй шарлаагүй, нарийн нунтагласан цагаан элсэн чихэр байна. Давс: MNS 5168:2021 Чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, иодын агууламж зохих түвшинд байна.</p> <p>Масло: Элдэв үнэр амтгүй, тослогийн хэмжээ стандартын шаардлага хангасан байна. Зориулалтын сав баглаа боодолтой байна. Ургамлын тос: Элдэв үнэр амтгүй, тослогийн хэмжээ стандартын шаардлага хангасан байна. Зориулалтын сав баглаа боодолтой үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Зориулалтын саванд савласан сав нь гэмтэж хагараагүй,</p> <p>Хадгалалтын хэвийн горимд хадгалсан чанарын шаардлага хангасан байна.</p> <p>Бусад хүнс: Исгэгч, Хуурай цай,</p> <p>Төмс хүнсний ногоо нь орон нутгийн хөрсөнд тариалагдсан элдэв химийн бордоогоор бордоогүй эрүүл аюулгүй чанартай хүнсний бүтээгдэхүүн байна. Шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна.</p> | | |
|--|--|--|

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.